



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 01340

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 12 дугаар
сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 8,511,745.50 /найман сая таван зуун арван нэгэн мянга долоон зуун дөчин таван төгрөг тавин мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 12 дугаар сургууль /М.Туулсайхан/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 3 нэр төрлийн 1,426,795 /нэг сая дөрвөн зуун хорин зургаан мянга долоон зуун ерэн таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 10 нэр төрлийн 7,084,950.50 /долоон сая наян дөрвөн мянга есөн зуун тавин төгрөг тавин мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 12 дугаар сургууль /М.Туулсайхан/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050000825

Нийслэлийн Өмчийн Ашиглалт Удирдлагын газрын
даргын 2020 оны 06 дугаар сарын 29 өдрийн
0/340 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: СХД-ийн 12-р сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХХК-ын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж											
1	проктер Epson	5	ш	1	2,790,000.00	2,790,000.00	2,790,000.00	0.00	эвдэрсэн	актлах	татах
2	мод боловсруулах суурь машин	11	ш	1	1,320,000.00	1,320,000.00	1,320,000.00	0.00	эвдэрсэн	актлах	татах
3	принтер MFP-T1120	11	ш	1	332,502.50	332,502.50	332,502.50	0.00	эвдэрсэн	актлах	татах
4	компьютер dual core	9	ш	1	764,000.00	764,000.00	764,000.00	0.00	эвдэрсэн	актлах	татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн				4.00		5,206,502.50	5,206,502.50	0.00			
Тавилга, эд хогшил											
1	сейф	21	ш	2	180,900.00	361,800.00	361,800.00	0.00	эвдэрсэн	актлах	татах
2	теннисний ширээ	21	ш	1	100,000.00	100,000.00	100,000.00	0.00	эвдэрсэн	актлах	татах
3	багш сандал	21	ш	1	18,729.00	18,729.00	18,729.00	0.00	эвдэрсэн	актлах	татах
4	ангийн самбар	17	ш	2	271,350.00	542,700.00	542,700.00	0.00	эвдэрсэн	актлах	татах
5	1 сурагч ширээ	12	ш	10	43,508.00	435,080.00	435,080.00	0.00	эвдэрсэн	актлах	устгах
6	бүтээл ханын шкаф	12	ш	2	385,000.00	770,000.00	770,000.00	0.00	эвдэрсэн	актлах	устгах
7	сурагч ширээ	12	ш	5	44,343.00	221,715.00	221,715.00	0.00	эвдэрсэн	актлах	устгах
8	төмөр шкаф	12	ш	2	330,000.00	660,000.00	660,000.00	0.00	эвдэрсэн	актлах	татах
9	теннисний ширээ	12	ш	1	195,219.00	195,219.00	195,219.00	0.00	эвдэрсэн	актлах	татах
Тавилга, эд хогшлын дүн				26		3,305,243.00	3,305,243.00	0.00			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				30.00	-	8,511,745.50	8,511,745.50	-			
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө				13.00		7,084,950.50	7,084,950.50	-			
Актлах хөрөнгө				17.00		1,426,795.00	1,426,795.00	-			